



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 10 дугаар сарын 14 өдөр Дугаар 50

Хэрлэнсүм

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 50 дугаар хуралдаан Онцгой комиссын ажиллах журмын 1.8-д заасны дагуу цомхотгосон хэлбэрээр 2020 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 11:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 94,8 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Аймгийн Онцгой комиссын 2020 оны 49 дүгээр хуралдааны 1.1 дэх заалтад тодотгол хийх, нөхцөл байдлыг танилцуулах

Аймгийн Тагнуулын газар

2.Цэрэг татлагад шаардлагатай халдвар, хамгааллын хэрэгслийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас шийдвэрлүүлэх

АЗДТГ-ын Цэргийн штаб

3.Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2020 оны "Хүйтний улиралд ариутгал, халдваргүйжүүлэлтийг зохион байгуулах тухай" 02/2770 дугаар албан бичгийг танилцуулах

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг,

Автотээврийн төвийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Мөнхтөр

Хилийн 0198 дугаар ангийн захирагч, хурандаа Б.Гантөгс нарт:

1.1."Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ийн газрын тосны тусгай зориулалтын тээврийн хэрэгслийг хилийн "Баянхошуу-Өвдөг" боомтоор нэвтрүүлэхдээ зөвхөн Монгол жолоочтой тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхийг,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын

гишүүн Д.Мөнхтуяа,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын

гишүүн Ч.Оюунаа нарт;

1.2.Хилийн "Баянхошуу-Өвдөг" боомтоор 2020 оны 10 дугаар сарын 13-ны өдөр тусгай зориулалтын тээврийн хэрэгслийг жолоодож ирсэн БНХАУ-ын 3 иргэнээс коронавирус илрүүлэх PCR шинжилгээ авах ажлын хэсгийг томилж ажиллуулах, шинжилгээ авахад гарсан зардлыг тухайн компаниас шийдвэрлүүлэхийг,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын

орлогч дарга, хурандаа Г.Нармандах-т;

1.3.Хил хамгаалах ерөнхий газрын дарга, бригадын генерал Ж.Бямбасүрэн, Хилийн дугаар ангийн захирагч, хурандаа Б.Гантөгс нарт "Аймгийн Онцгой комиссын хуралдааны шийдвэрээр хилийн"Баянхошуу-Өвдөг" боомтоор газрын тосны бүтээгдэхүүн тээвэрлэх, тусгай зориулалтын автомашин, жолооч нарыг нэвтрүүлэхтэй холбоотой асуудлаар хамтран ажиллах тухай" албан бичгийг аймгийн Онцгой комиссоос хүргүүлэхийг

Хоёр.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын

орлогч дарга, хурандаа Г.Нармандах-т;

2.1.Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас аймгийн Онцгой комисст ирүүлсэн саналын дагуу Цэрэг татлагын үед ариутгал, халдваргүйтгэл хийхэд шаардлагатай амны хаалт 1000 ширхэг, ариутгалын бодис 10 ширхэг, бээлий 200 ширхэгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас олгохыг,

Гурав.Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар,

Цагдаагийн газар, Гаалийн газар,

Гадаадын иргэний харьяатын Зүүн бүсийн дэх газар,

Хил хамгаалах байгууллага,

Автотээврийн төвийн дарга нарт;

3.1.Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2020 оны "Хүйтний улиралд ариутгал, халдваргүйжүүлэлт хийх тухай" 02/2770 дугаар албан бичгийн 1 дэх заалтын дагуу хилээр нэвтрүүлж буй бүх төрлийн тээврийн хэрэгсэлд халдваргүйтгэл хийхдээ хуурай бодисоор туулуулах арга ашиглан дугуйг бүтэн өнхөрөх байдлаар туулах халдваргүйжүүлэлтийн бодисын урт 4 метрээс багагүй байхаар бэлтгэх,

3.2.Хилийн боомт болон гүний гаалийн хяналтын бүс дээр халдвар тархах нөхцөл, дамжих замыг тодорхойлж, эрсдэл бүхий орчин, гадаргууд чиглэсэн халдваргүйжүүлэлтийг хийх,

3.3.Хүйтний улиралд тээврийн хэрэгсэл, жолооч, зорчигчийн эд зүйлс, хүрэлцэхүйц гадаргууг нөхцөл байдалд тохируулан мананцаржуулах аргаар ариутгаж халдваргүйжүүлэхийг,

3.4."Коронавируст халдварын үед уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагааг онцгой нөхцөлд зохион байгуулах түр журам"-ын 2.3-д заасны дагуу халдваргүйжүүлэлтийн байгууламжийг дулаалж, тоноглох үүрэг бүхий албан бичгийг Мэргэжлийн хяналтын газраас "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-д хүргүүлэхийг,

3.5.Улс хоорондын ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаа гүйцэтгэж буй жолооч нарыг халдвараас сэргийлэх дэглэм, ариутгал, халдваргүйжүүлэлтийн талаар үе шаттайгаар сургалтад хамруулахыг Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газруудад,

3.6.Ариутгагч нарыг мэргэшүүлэх, тэдгээрийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг ханган эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулж, ажлын байрны эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах чиглэлээр Мэргэжлийн хяналт газар, Эрүүл мэндийн газар, Автотээврийн төв, Замын цагдаагийн алба хамтран ажиллахыг,


Дөрөв.Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,

Гаалийн газрын дарга,Онцгой комиссын гишүүн Б.Гэрэлт-Од нарт.


4.1.Хилийн хяналт, шалгалтын ажлыг эрчимжүүлэн хууль бус бараа бүтээгдэхүүн орж ирэхээс урьдчилан сэргийлж ажиллан сар бүр мэдээлж байхыг,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг-т,

4.2."ДБЭХС" ТӨХК-ийн хүчин чадлыг 50МВт-аар өргөтгөх төслийн БНХАУ-ын ажилчдын байрнаас БНХАУ-д үйлдвэрлэсэн согтууруулах ундааны зүйл олноор илэрсэн тохиолдлыг холбогдох хууль, журмын дагуу шалгаж, аймгийн Онцгой комиссын 51 дүгээр хуралд танилцуулахыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА  М.БАДАМСҮРЭН



АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА, ДЭД ХУРАНДАА  Д.БАТТУЛГА